



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 02 сарын 03-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

### НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 6 дугаар бүлэг, 76 дугаар зүйлийн 76.1 дэх хэсэг, “Сүү” ХК-ийн дүрмийн 8 дугаар бүлгийн 8.15.15 дахь хэсэг, 11 дүгээр бүлэг болон 2026 оны 02 сарын 03-ны өдөр хуралдсан “Сүү” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сүү” ХК-ийн 2025 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас 1,746,542,679.13 /Нэг тэрбум долоон зуун дөчин зургаан сая таван зуун дөчин хоёр мянга зургаан зуун далан есөн төгрөг арван гурван мөнгө/ төгрөгийг нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон олгохыг зөвшөөрсүгэй.
2. “Сүү” ХК-ийн нэгж хувьцаа тус бүрд 5.09 /Таван төгрөг есөн мөнгө/ төгрөгийн ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр олгож, ногдол ашгийг тараах, түүнтэй холбоотой ажлыг зохион байгуулах, холбогдох баримт бичигт компанийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Б.Гантулга/-д олгосугай.
3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг “Сүү” ХК-ийн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
4. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд 2026 оны 04 сарын 30-ны өдрийн дотор тарааж дуусгасугай.
5. Энэхүү шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Гантулга/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ГАНБААТАР